



ТӨВ АЙМГИЙН НАМЫН ХОРОО,
АДХ ГҮЙЦЭГТЭХ ЗАХИГГАНЫ СОНИН.

13 дэх жилдээ	1961 оны	ПҮРЭВ
53 (10101)	7 дугаар сарын 6	

Мал өсгөх төлөвлөгөө бол манай аймгийн хөдөлмөрчдийн дайчин зорилт мөн

Манай нам засгаас эх орон эдийн засгийн гол салбар болсон мал аж ахуйг өсгөн хөгжүүлэх, ашиг шинийн нь нэмэгдүүлж бүрэн ашиглах талаар олон чухал арга хэмжээнүүд авч байна.

Тус аймагт 3 дугаар 5 жилийн төлөвлөгөөгөөр танигдаж байгаа гол зорилт бол мал өсгөх улсын төлөвлөгөө юм.

Манай аймаг 1961 онд улсаас өгсөн төлөвлөгөөгөөр 1960 онд байсан малаа 2,2 хувиар өсгөх бөгөөд өөрийн бодит бололцоонд түшиглэн улсын төлөвлөгөөгөөр өгөгдсөн малын цэвэр өсөлтийг 3 хувиар нэмэгдүүлж өнгөрсөн онд байсан малаа 31873 толгойгоор нэмэгдүүлэхээр үүрэг аваад ажиллаж байна.

Аймгийн намын хорооны V бүгд хурал, тус аймаг өнгөрсөн 4 жил дараалан малаа хөгжүүлж хээлтэгч малын хувийн жинг бууруулж, бойжуулах төлний тоог хөргөдүүлсэн зэрэг ноцтой дутагдалд гүнзгий дүнгэлт хийгээд 1961 оныг мал өсгөх эргэлтийн он болгох дайчин зорилтыг дэвшүүлэн тавьсан билээ.

Аймгийн намын бүгд хурлын энэ шийдвэрийг манай хөдөлмөрчид баяртай хүлээн аваад шаргуу ажиллахаар байгаа.

Өнгөрсөн жил Бүрэн сум малаа 5 төрөл дээр нь өсгөж, мал өсгөх төлөвлөгөөг Эрдэнэсант сум, станцууд 5,9-18,2 хувиар давуулан биелүүлсэн нь байгаа бололцоогоо бүрэн ашиглаж тодорхой ажиллавал мал өсгөх төлөвлөгөөг бүрэн хангаж болохыг нотлож байна.

Аймгийн хэмжээгээр малын төл 95,4 хувиар бойжиж байгаа ба малын төрөл бүрийн зарлагыг багасгаснаар 1961 онд мал өсгөх улсын төлөвлөгөөг давуулж, нам улсынхаа өмнө амалсан, мал өсгөх зорилтоо биелүүлэх боломжийг олгоо.

ХӨДӨЛМӨРЧДИЙН ЦУГЛААН

МАХН-ын 14 дүгээр их хурал нэгдсэнтэй холбогдуулан хөдөлмөрчдийн цуглаан 7 дугаар сарын 3-нд соёлын ордонд болж Тус цуглаан дээр намын хорооны 2 дугаар нарийн бичгийн дарга Дамбажавч МАХН-ын 14 дүгээр их хурал нэгдсэн тухай товч үг хэлэв.

Дамбажавч хэлэхдээ: Намынхаа 11 дүгээр их хурлыг тус аймгийн хөдөлмөрчид 1961 оны эхний хагас жилийн аж ахуй, соёлын төлөвлөгөөг биелүүлж хөдөлмөрийн гялалдсан амжилтаар угтаж их хурмынхаа ажиллагааг сэтгэл хангамжтай сонсож байна гэж онцлон тэмдэглэв.

Дараа нь эргэрийн явилчин Дула-сүрэн, намын хорооны ажилтан Цэнд-аршин олон хүн үг хэлж намынхаа 14 дүгээр их хурал нэгдсэн тухай мэдээг сонсож хязгааргүй баяртай байгаагаа илэрхийлэхийн хамт өөрсдийн ажил дээр тодорхой бүтээл гаргахаар өндөр үүрэг авчгаав.

Гэвч аймгийн намын бага, бүгд хурлаас тавьсан зорилтыг хангалтгүй биелүүлж нилээд сумд төлийн ба малын зүй бусын хөргөдлийг багасгах талаар тодорхой арга хэмжээ авч чадаагүй байна.

1961 оны эхний хагас жилийн дүнгээс үзвэл: Баян-чандмань, Борнуур, Батсүмбэр зэрэг сумд мал өсгөх төлөвлөгөөг 4-31 хувиар таслах байдалтай байна.

Энэ учраас нийт сумд малын зүй бусын хөргөдлийг эрс багасгаж төрөл бүрийн зарлагыг нарийн тооцож уралдаанд авсан үүргээ биелүүлэх талаар тодорхой ажил зохиох хэрэгтэй.

Тус аймгийн нам улс, олоот нийтийн байгууллага нэгэн бүхэн өөрийн ажлыг мал өсгөх тэмцэлд чиглүүлж 1961 оныг мал өсгөх эргэлтийн он болгохоор аймгийн намын бүгд хурлаас дэвшүүлсэн зорилтыг биелүүлэхэд байгаа бүх хүчээ дайчлан ажиллах хэрэгтэй.

Мал эмнэлгийн байгууллагын эмч зоотехникч нар, мал ажиллагаанд шинжлэх ухааны арга техникийг нэвтрүүлж малын төрөл бүрийн өвчнийг устгах талаар мэргийн ажиллаж өвчтэй малд эмчилгээ сайн хийж нэгч толгой малыг хөргөдүүлэхгүйн төлөө шамдан ажиллавал зохино.

Малчдын дотор социалист уралдааныг эрчимтэй өрнүүлэн дэлгэрүүлж, малын харчулга малаагаа сайн байлгаж зүй бусын хөргөдлийг эрс багасгах талаар хүн бүхэн санаа тавих нь чухал. Намын суртал ухуулга, олон түмний ажлыг мал өсгөх зорилтот чиглүүлэн зохиож мал өсгөхийн эдийн засгийн ач холбогдлыг малчид бүрт сайн ойлгуулах хэрэгтэй.

Манай бүх ажил үүнд чиглэснээр 1961 онд мал өсгөх төлөвлөгөөг биелүүлж чадна.

Эрдэнэсант сумын МААМ станцын хамт олон, МАХ Намын 14 дүгээр их хурал, ардын хувьсгалын 40 жилийн ойг угтаж социалист уралдаанд авсан үүргээ давуулан биелүүлж байна.

Энэ станцынхан хавран тариалангийн ажлыг богино хугацаанд дуусгаж зорилгоор бэлтгэл ажлыг урьдаас сайн хангаж, машин техникийн хүч чадлыг бүрэн ашиглаж бригад, хэсэг хүн бүрийн хооронд уралдаантай ажиллажээ.

Тус станц, Өндөрлөрөөт, Эрдэнэсант, Лүн, Дэлгэрхаан, Тариат, Онжүүл, Бүрэн зэрэг 7 сум-нэгдэлд 5203 га газар хагалан, үр тариа, хүнсний ногоо, эрдэнэ шиш, тэжээлийн ургамал тариалж 2600 га пар хагалж, энэ бүх ажлыг 45 хоногт багтааж төлөвлөгөөг 0,6-11,7 хувиар давуулан биелүүлж 20 шахам тонн шатхуун хэмнэж, улсад 7000 төгрөгийн орлого оруулсан байна.

Чадраабал ахлагчтай СХТ бригадын тракторчид ажлын 10-хоногт 1654 га атар


газар хагалж 1436 га-д үр суулгаж төлөвлөгөөгөө 126 хувиар биелүүлж 3000 кг шатхуун хэмнэжээ.

Бригадын гишүүн тракторч Түдэвжанцан Чойсүрэн, Чойжамц, Очирбат нар 45 хоногт 417-555 га газар хагалж 209-250 га-г борнойдож, 560-700 литр шатхуун хэмнэж төлөвлөгөөгөө 67-100 хувиар давуулан биелүүлж сайхан амжилт гаргасан байна.

Станцынхан ардын хувьсгалын 40 жилийн ойг угтаж хадлан авалт, намрын тариа хураалтын бэлтгэл ажлыг одоогоос эхлэн хийж байна.

МААМ станцын захиргаа, хадлан авалт, тариа хураалтын бэлтгэлийг хангах 45 хоногийн цохцтой ажил зохиож хадлан, тариалангийн үеэр хэрэглэх орон сууц, хоол хэрэглэлийн зүйлийг хүрэлцээтэй бэлтгэж трактор хадуур 6, морин хадуур 12, комбайн 6, нуруулдагч 2, бухалдагч 1-ийг засварлаж бэлэн болгоод байна.

Д. ДОНДОГДОРЖ



ЗУРАГ ДЭЭР: Аймгийн дүрслэх урлагийн салбарын мужаар Базарсүрэн, залуу сийлбэрч Лувсан, өвгөн Гомбожав нар намын 14 дүгээр их хурал, ардын хувьсгалын 40 жилийн ойг угтаж өөрсдийн санаачлагаар чанар үзэмж сайтай 30 морин хуур хийж аймгийн соёлын ордонд бэлтгэв (Дугаар авсан гэрэл зураг).

И х о й н ө м н ө

Аймгийн соёл урлагийн байгууллагууд ардын хувьсгалын 40 жилийн ой, МАХ Намын 14 дүгээр их хурлыг угтаж авсан амьдрал үүргүүдээ амжилттай биелүүлж байна. Гомбожав даргатай аймгийн соёлын ордон 1961 оны эхний хагас жилийн уран бүтээлийн төлөвлөгөөг 150 хувиар биелүүлжээ.

Үүний дүнд 1961 оны тэргүүн хагас жилийн тоглолт, үзэгчид, орлогын төлөвлөгөөг 115 хувиар биелүүлэв.

Аймгийн соёлын хэлтэс нийт сум, сангийн аж ахуйн улаан булан 25, клуб 7-д урлагийн тоглолт, тохижуулалтанд үзлэг явуулж шалгаруулан байр эзлүүлсэн байна.

Аймгийн төв хөдөөгийн морин хуурч ардын дуучдын уралдааныг явуулж аймгийн «Алдарт дууч», «Аврага хуурч» цол олгосон ба морин хуурч 30 хүн оролцсон концерт аймгийн төвд тоглуулав.

Хөдөө аж ахуйн нэгдлийн 133 бригадын 50 хувийг улаан булантай болгожээ.

Аймгийн төвийн суурин кино (механик Готов) эхний

хагас жилд 210 удаа кино гаргаж 29400 хүнд үзүүлэн, 39000 төгрөгийн орлого оруулж кино гаргалт, үзэгчид, орлогын төлөвлөгөөг 110 хувь, жилийн төлөвлөгөөний 60 хувийг гүйцэтгээд байна.

Сум-нэгдэл, сангийн аж ахуйн дэргэдэх нүүдлийн кинонууд кино гаргалт үзэгчид, орлогын төлөвлөгөөний 65 хувийг биелүүлээд байгаагийн дотор Завмар сумын Цэдэвсүрэн, Баянзүрх сумын Соном, Онжүүл сумын Дамжаа, Угтаалцайдам сумын Доолио нарын 20 гаруй кино механик кино гаргалт, үзэгчид, орлогын жилийн төлөвлөгөөний 60-65 хувийг биелүүлсэн байна.

Дүрслэх урлагийн салбарын мужаар Базарсүрэн залуу сийлбэрч Лувсан, Барималч Гомбожав нар өөрсдийн санаачлагаар чанар үзэмж сайтай морин хуур 30-ыг хийж аймгийнхаа соёлын ордонд бэлэглэжээ.

Нэг ээлжинд 100 хүнд үйлдлэх танхимтай тохилог сайхан номын санг ашигласнаар оруулахын хамт аймгийнхаа нутгийн хөрс, ургамал, ан амьтан, байгалийн

баялаг түүхийн дурсгалт зүйл, үйлдвэр, хөдөө аж ахуй, соёл гэгээрлийн хөгжлийг сурталчлах 11 тасалгаа бүхий улс ардын аж ахуйн үзэсгэлэнгийн барилдагч ардын хувьсгалын 40 жилийн ойн өмнө ашиглалтанд оруулах гэж байна.

Энэ барилгуудыг баруулах ажилд орон нутгийг судлах кабинетын эрхлэгч Жадамбаа, номын сангийн эрхлэгч Жамъяндампил нар идэвх зүтгэлтэй ажиллаж байна. Аймгийн утга зохиолын дугуйлангийнхны бүтээл шүлэг, дуу, өгүүдлэг, найрууллагыг эмхтгэж «Тариан долно» гэдэг эмхтгэл, С. Гүнрэгжавын зохиолын эмхтгэл «Сэтгэлд ассан мөнхийн зул» гэдэг номуудыг хэвлэн гаргаж гэж байгаа ба «Төв аймаг» гэсэн фото зургийн альбом хийж нийтийн худалдаанд гаргах гэж байна.

Дээрх ажлын амжилт бол манай соёл урлагийн байгууллагуудаас ардын хувьсгалын 40 жилийн ойдоо барьж байгаа бэлэг юм.

Дандарын

БАЯНЦАГААН СУМЫН ХӨДӨЛМӨРЧДӨӨС 1961 ОНД СОШИАЛИСТ УРАЛДААНД АВСАН ҮҮРЭГ

а. Хөдөө аж ахуйн талаар

1. 1961 оны мал өсгөх төлөвлөгөөг 0,5 хувьнаа давуулан биелүүлж 87799 толгой малтай болно.

2. Хамуу, галзуу зэрэг халдварт өвчнийг бүрэн устгаж, урьдчилан сэргийлэх тарилга, угаалга, туулгалтын төлөвлөгөөг 102 хувиар биелүүлнэ.

3. 6000 хонинд зохиомол хээлтүүлэг хийж 500 хонинд ихэрлүүлэх туршлага хийнэ. Бүх хээтгүүдэгч малд үзлэг хийж гэрчилгээ олгож шаардагдах хээлтүүлэгч малыг шинээр нэмэн тавина.

4. 100 га-д овьёос, арвай тарьж 5 га газарти элшний ногоо тарина.

5. Бод малын хашаа 22, цүнз 13, бөгийн хашаа 47, цүнз 55-ыг барьж худга 5-ыг гаргаж 10-ыг засварлан, булаг 1-ийг тохижуулна.

6. Удсын орлогын төлөвлөгөөг 100 хувиар биелүүлнэ.

б. Нэгдлийн үйлдвэрлэлийн талаар

1. Тус сумын Өрнөх амьдрал нэгдэл 1 сая 76 мянган төгрөгийн мөнгөн орлого оруулж үл хуваагдах фондоо 107,6 мянган төгрөгөөр арившуулж нэг хөдөлмөрч өдөрт бие үйлдэхүүний хамт 5 төгрөг 50 мөнгө олгож өнгөрсөн оноос 25 хувиар нэмэгдүүлнэ.

2. Нэгдэл 200 хүний багтаамжтай клубын дутуу барилгыг дуусгах, зочид буудал бүхий гуанзны нэгдсэн барилга, талх, боовны газар, 4 айлын орон сууц 2, бригадын төвд контор бүхий улаан булан, төрөлжсөн агуулах зэрэг барилга байгууллагуудыг барьж ашиглалтанд оруулах ба үүний 50 хувийг ардын хувьсгалын 40 жилийн ойн наана барьж дуусгана.

в. Худалдаа бэлтгэлийн талаар

1. Бараа татан авалтыг хугацаанаас нь 30 хоногийн өмнө 102,1 хувь, бараа борлогч 10 хоногийн өмнө 101 хувь, үүний дотроос номын гүйлгээг 103 хувиар давуулан нэг өрхөд худалдах үндсэн нэрийн барааны хэмжээг өнгөрсөн оныхоос 5 хувиар нэмэгдүүлнэ.

3. Мал бэлтгэлийг 5 хоногт багтааж тарга хүчний төлөвлөгөөг 2 хувиар давуулан биелүүлнэ.

4. Төлийн арьс, бодын хөөвөр, ноолуур, уртын ноос, ямааны хялгас, тэмээний ноос, тарваганы арьс тосыг аймгаас өгсөн графикт заасан хугацаанд 100—105 хувиар биелүүлнэ.

5. Арьс ширний төлөвлөгөөг хугацаанаас нь 5—7 хоногийн дотор 1—5 хувь, ангийн үсийг 101 хувь, техникийн тос, өлөн гэдэс, яс бэлтгэлийг 1—3 хувь, бусад түүхийг эдийг 2—5 хувиар давуулан биелүүлнэ.

6. Бүх авсан ноолуурын 90-ээс доошгүй хувийг 60 хувийн чанартай бэлтгэх ба бэлтгэсэн төлийн арьсыг 100 хувь, адууны шир, хонь ямааны арьсны 10—20

хувийг давсгаж хатаах, арьс ширнийг дэвтээх цовдлох, ангийн үсийг хангаж, арьс ширний 70—90 хувийг зөөлөн үсийг 70 хувь, хөлдүүгийн 70—100 хувийг 1,2 дугаар зэрэгт тушааж бэлтгэлийн чанарын дарагдлыг бүрэн арилгах.

7. Бэлтгэлийн ажиллагааны зардлыг 1 хувиар хорогдуулна.

Худалдааны ажлыг сурталчлах бүтэн нэгнийг ажилдуулах тэргүүний туршлага 2-ыг амжилдаа нэвтрүүлнэ.

г. Бусад ажлын талаар

1. Сүү тосны заводын бэлтгэлийг хангаж 5 дугаар сарын 15-наас 2 тасагтайгаар нэгдэл ба албан хаагчдын улсад шийлүүлэх сүүг 9 дүгээр сарын 20-ны дотор багтаан авч сүүний төлөвлөгөөг 100 хувь, тосны төлөвлөгөөг 102 хувиар биелүүлж бүх тосны 90-ээс доошгүй хувийг 1 дүгээр зэрэгт тушааж 1 кг. тосонд 300 г-аас доошгүй сүү хэмнэж шингэн сүүг бүрэн ашиглана.

д. Соёл гэгээрлийн талаар

Сумын хэмжээний 8—12 насны хүүхдийг сургуульд бүрэн хамарч элсэлтийн төлөвлөгөөг 100 хувиар хангах.

2. Сургуулийн аж ахуйн засварыг багш ажилчид өөрсдөө хийж 7 дугаар сарын 10-ны дотор дуусгах ба түлшний 6 дугаар сарын 15 ны дотор бүрэн бэлтгэж татан авч дуусгана.

3. Хөдөлмөрийн хичээлийн танхим нэгийг барьж ашиглалтанд оруулна.

4. Сургуулийн туршлагын талбайд төмс, эрдэнэ шиш тарьж 500 кг-аас доошгүй идэшний ногоо тарьж ашиглах ба тэжээмэл амьтантай болно.

5. Жүжиг, цомог гараа үзэгдэл, концертын программ 17-т боловсруулан тоглож 2000 төгрөгийн цэвэр орлоготой ажиллана.

Кино гаргалтыг өөрийн аймгийн Заамар нэгдлийн тушлагыг эзэмшиж хэсүүчлэн гаргаж гаргалтын төлөвлөгөөг 10 хувиар давуулж, орлогын төлөвлөгөөг 100,5 хувиар биелүүлнэ.

6. Шинээр баригдаж байгаа клубын барилгыг барьж дуусгана. Одоогийн үлдэж байгаа 35-аас доош насны 27 хүнийг улсын баярын наана бичигтэн болгох ба сумын хэмжээний 45-аас доош насны хүмүүсийг үндсэнд нь бичигтэн болгоно. Хадлан авалт тарваганы арьс бэлтгэх төлөвлөгөөний 60 хувнаас доошгүйг залуучуудын хүчээр хийлгэнэ.


7. Амбулаторийн үзлэг, ор хоног, урьдчилан сэргийлэх тарилгын төлөвлөгөөг 101-115,9 хувиар биелүүлнэ.

8. Аж ахуйн талаар өөрсдийн хүчээр өвчингийн усанд оруулах ба угаалганы байшин агуулах барина.

Сумын Захиргааны дарга
Намын үүргийн дарга
Үйлдвэрчний хорооны дарга
Эвлэлийн үүргийн дарга

СУХБААТАР
ДАГВА
САМБУУ
МАНАЛ

Зөвлөлт Холбоот Улсад



Цөмийн шинжилгээний нэгдсэн институтын лабораторид атомын цөмийг цахилгаан нарийн шинжлэх зорилгоор түргэн нейтрон гаргаж авах атом задалгыг нарийн ажиллагаатай реактор зохион тавьжээ.
ЗУРАГ ДЭЭР: Атомын шинэ реактор.

Сайн санаачлага сайхан тусалцаа

БНМАУ-ын барилга ба барилгын материалын үйлдвэрийн яамны харьяа Ерөөгийн модны үйлдвэрийн хамт олон хөдөө аж ахуйн нэгдлийн үйлдвэрлэлийг цахилгаанжуулах ажилд их анхаарч туслаж байна. Энэ үйлдвэрийн Авирмэд ахлагчтай СХТ бригадынхан нэгдлийн модны үйлдвэрийн ажиллагааг механикжуулах зорилгоор Лүн сумын Энхтуул нэгдлийн төвд 5 хүн 7 хоног ажиллаж 55 ки цагийн чадалтай цахилгаан тавьжээ. Үүнээс салбарлаж харуул, хөрөө, өрөм, хасуур, лантуу

зэрэг 6-7 зүйлийг цахилгаанаар хөдөлгөх болгожээ. Ингэх нэгдлийн модны үйлдвэрийг цахилгаанжуулснаас хөдөлмөрийн бүтээл 28 хувиар дээшлэж, 10 хүний 5 өдөрт хийдэг ажлыг 16 цагт хийдэг болсон байна. Энэ станцыг байгуулан тавих ажилд СХТ бригадын гишүүн механикч Загаржав, өвгөн партизан Доржпалам нар илэвхтэй ажиллаж уг машиннуудыг ажиллуулах арга барилыг нэгдлийн гишүүдэд зааж өгсөн явдалд нэгдлийн хамт олон талархаж байна.

Д. ДОНДОГ.

Аймгийн ХЗ Эвлэлийн хорооны бүгд хурал

ХАА-ын нэгдлийн бригад суурьшудыг суурьшуулж тохижуулъя

Аймгийн ХЗ Эвлэлийн хорооны 5 дугаар бүгд хурал сайхан болж «Хөдөө аж ахуйн нэгдлийн бригад суурьшудыг суурьшуулахад МХЗ Эвлэлийн гүйцэтгэх ажил» гэсэн нэгдлийн аймгийн ХЗ Эвлэлийн хорооны 1 дүгээр нарийн бичгийн дарга Жадамба тавьж хэлэлцүүлэв. Тус аймгийн ХЗ Эвлэлийн хороо, МАХН-ын 14 дүгээр их хурал, ардын хувьсгалын 40 жилийн ойг угтаж, аймгийн нам улсын байгууллагын туслалцаатайгаар хөдөлмөрийн тэргүүний сайчуудын анхдугаар чуулганыг санаачлан явуулж тэргүүний хүмүүсийн ажлын арга туршлага, шинэ санаачлагыг харилцан солилцуулж мал сүргийг өсгөн, ашиг шимийг нэмэгдүүлж арчи-

гаа маллагаагийн нь сайжруулахтай холбогдсон чухал шийдвэр гаргасан нь зохих үр дүнгээ өгч байна. Мал төлөвлөлийн ажилд 2000 гаруй гишүүд залуучууд ажиллаж 127026 эх малаас 126592 төл хүлээн авч, гарсан төлөө 99,1 хувиар бойжуулсан байна. Тус аймгийн залуучууд төлийг хөврийн аргаар бойжуулах тушлагыг өргөн хэрэглэсэн нь төлийг хорогдоогүй бойжуулах аятай нөхцөл нь болжээ. Эвлэлийн гишүүд залуучууд малын ноос, хөөвөр авах ажлын 70 хувийг гүйцэтгэх үүрэг авч олон зуун залуучууд ажиллаж амласан үүргээ нэр төртэй биелүүджээ. Аймгийн ХЗ Эвлэлийн

хороо нэгдлийн үйлдвэрлэлд гишүүд залуучуудын хүчийг зөв хувиарлах хамт залуучуудын дунд хөдөлмөрийн үзлэг явуулж тодорхой ажилд үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт хувирлан өгч ажиллуулжээ. Аймгийн эвлэлийн гишүүд залуучууд энэ оны эхний хагас жилд бод малын зохиомол хээлтүүлгийн байр 25, орон сууцны барилга 12, клуб 2, улаан булан 6, халуун усны барилга 4, саалын үнээний байр 8, бог бод малын хашаа 42-ыг барьж нэгдлүүдэд 69000 төгрөгийн ашиг оруулсан байна. Заамар нэгдлийн саальчин ХЗ Эвлэлийн гишүүн Элнээ, Жавзандадам ахлагчтай СХТ бригадын залуучууд 120-150 үнээний байр 2, 60-75 тугалын цүнз 2, үхрийн тэжээлийн хашаа 4, халуун усны барилга 1, хашаа 22-ыг эвлэлийн байгуул-

агуулах 1-ийг тус тус барьж суурна тохижуулахын төлөө их зүйлийг санаачлан хийж байна. ХАА-ын нэгдлийн суурь бригадыг суурьшуулан тохижуулах талаар залуучуудын хийсэн ажлын олон сайхан баримтыг дурдаж болно. Ажлын нйм амжилт байгаа боловч аймгийн ХЗ эвлэлийн орон нутгийн зарим үүр хороодын зохиож байгаа ажил хангалтгүй байгаа дутагдлыг бүгд хурлынхан хурцаар илэрүүлэн шүүмжлэв. Бүгд хурал, аймгийн хэмжээгээр 22 бригад, 26 суурьжиг МХЗ Эвлэлийн нэрэмжит үлгэр жинээ суурь бригад болгох эдгээр бригад суурийн төвд 1961-1963 онд 541 айлын орон сууцны барилга, улаан булан 22, халуун усны барилга 22, хуун эмнэлгийн амбулаторь 22, худга 48, малын тохилог хашаа 22-ыг эвлэлийн байгуул-

лагууд хариуцан, гишүүд залуучуудын хүчээр барьж байгуулахаар шийдвэрлэв. 1961 онд багтааж эвлэлийн гишүүд залуучууд бүрийг барилгын багаж хэрэгсэлтэй болгож барилга барих ахны мэдэгдэхүүн эзэмшүүлэх бригад суурийг суурьшуулахад хэрэглэгдэх барилгын материалыг 1961-1962 онд бүрэн хангаж 1962-1963 онд бүх барилгаа барьж дуусгах тодорхой төлөвлөгөөг бүгд хурлынхан санал нэгтгэй батлав. Бүгд хуралд МХЗ Эвлэлийн Төв Хорооны нарийн бичгийн дарга Очирбал, Аймгийн АДХ Гүйцэтгэх захиргааны дарга Жамсран нар үг хэлж эвлэлийн байгууллагын ажлын оларт амжилтыг дүгнэн нэ шдны ажилд холбогдуулан дэлгэрэнгүй үг хэлэв.

Д.Дондогдорж

МАНАЙ СОНИНЫ БАГА ХУРАЛ

Уншигчид аа!

«Хөдөлмөр бол амьдралын эх булаг» гэсэн сэдвээр явуулж байгаа манай сонины бага хурлын ажиллагаа энэ дугаараар төгсгөө.

Манай сонины бага хурал МХЗЭ-ийн ажилтан гишүүд, малчин, ажилчин, сэхэстэн олон хүмүүс оролцож хөдөлмөрийн үнэ цэнийн талаар ярилцсан нь үр дүнгээ өглөө гэж сонины редакци үзэж байна.

Цаашилд сонины бага хурлаар нийтлэгдсэн шүүмжлэлтийн хэрээр тодорхой ажил зохиож явдал МХЗЭ-ийн байгууллагуудын чухал үүрэг болж байна.

Сонины редакци.

Хөдөлмөрт оруулъя

Анхдугаар таван жил сони өөрийн дугааруудар «Хөдөлмөр бол амьдралын эх булаг» гэсэн асуудлаар бага хурал явуулж байгаа нь цаг үеэ олон чухал асуудал бөгөөд хүмүүст хөдөлмөр хийхийн чухлыг сийгуулж тэднийг нийгмийн хөдөлмөрт үр ашгтай оролцон ажилдаа өндөр бүтээл гаргаж гэсэн санаа зоригийг нь улам өрнүүлж байна.

Манай Өндөрширээт суманд хөдөлмөрийн ач тусыг ойлгож нийгмийн хөдөлмөрт үр бүтээлтэй оролцох явдал бараг бүх нийтийн хэрэг болжээ.

Гэвч зарим цөөн хүмүүс өгт ажилгүй байх, тогтмол биш ажиллах явдал бай а. Ийм хүмүүсийн тоонд орох хэдэн хүнийг нэрлэн дурдгал:

1 дүгээр бригадын залуу Товуучий, Молом, Эртэнэ, Давалдорж, Сэрээнэн, 2 дугаар бригадын залуу Пүрэв, Сүндүй нар орно.

Энэ Залуучууд эрхэлсэн тодорхой хөдөлмөргүй учир өөр аймаг сум дамжин айл хэсэг явдаг байна.

Эднийг хөдөлмөрт даруй оруулах нь чухал юм.

ЧҮЛТЭМ

Шүүмжлэлтэй хандъя

«Хөдөлмөр бол амьдралын эх булаг» гэсэн сэдвээр сонины бага хурал зохиож байгаад талархаж ажилгүй залуучуудыг бүрэн ажилд оруулах талаар үр ашгтай зүйл болно гэж итгэж байна.

Хөдөлмөргүй байгаа залуучуудыг ажилд оруулах талаар эвлэлийн хорооноос сонины хуудсаар зохиож байгаа энэ ажлыг дэмжиж аймгийн хэмжээгээр ялангуяа сум-нэгдлийн эвлэлийн үүрүүд тодорхой далайцтай ажил зогсолтгүй зохиох хэрэгтэй.

Ажлыг ор нэр болгон гүйцэтгэж өгсөн үүрэг даалгаврыг үл биелүүлдэг, амар хялбараар ажил-

лахыг бодогчид зэрэг хөдөлмөрийг үнэлж хүндэтгэдэггүй, хүнд суртлын залуу хойрго этгээдүүдийг өргөн шүүмжлэн засах явдал чухал юм.

Ер нь огт ажил хийгээгүй ажилгүй байгаа хүнээс ажил хийсэн болж ажлыг оронцоглож ажил хийдүүлж сулруулж, амина аргаагаарч этгээдүүд манай ажлын гүйцэтгэлд илүү хохирол учруулж байна.

Ийм болохоор эдэнтэй хатуу тэмцэл хийж шүүмжлэх хэрэгтэй гэж үзэж байна.

Бүрэн сум-нэгдлийн дарга

Я.Пүрэвжил

Заамар сум нэгдлийн хөдөлмөрчдөөс 1961 онд социалист уралдаанд авсан үүрэг

НЭГ. Мал аж ахуйн талаар

1. Сумын хэмжээгээр 1961 онд мал өсгөх улсын төлөвлөгөөг төрөл бүр дээр нь 103,7 хувиар буюу 1953 төлөвлөгөөг давуулна.

Нэгдэл 1961—12—30-нд байсан бүх малаа 10,7 хувиар өсгөж, 160 хээлтэгч дутмаас ботго 40, унага 55, тугал, ншиг 75, хурга 85-ыг бойжуулан авна.

2. Нэгдлийн хээлтэгч малын тоог 7,9 хувиар өсгөхийн хячт бүх малайн дотор хээлтэгч малын хувийн жинг 46,7 хувьд баалгана.

3. Мал бүрээс ашиглах ашиг шимийг өнгөрсөн оныхоос эрс дээшлүүлж хонины ноос 1,3, ахар хурга 0,4, тэмээний ноос 5, ямааны ноос 0,22, ямааны ноолуур 0,23, хөөвөр 0,3 хялгас 0,5 кг тус тус авна.

Үнээний сүү 500, гүүний сүү 200, хонь ямааны сүү 10-15 л. ингэнээс 90 л. сүү ашиглана.

4. Төрөл бүрийн өвчнөөр мал үхэх явдал 1960 оныхоос 30 хувиар багасгаж үүний дотор эргүүдэх үхэх явдал 80 хувиар багасгаж хамуу өвчнийг бүрэн устгана.

Урьдчилан сэргийлэх тарилга эмчилгээний төлөвлөгөөг хугацаанд нь гүйцэтгэж төрөл бүрийн тарилгын төлөвлөгөөг 100,1-249 хувиар биелүүлнэ.

Өөрсдийн хүчээр суурин вань 1-ийг шинээр барьж 2-ыг сэлбэн засварлана.

Алтау үүлдрийн бухар 400 үнэнд, алтай цыгай үүлдрийн хуучар 4000 хониод зохиомол хээлтүүлэг хийнэ.

5. Өвс хадлангийн бэлтгэлийг 7 дугаар сарын нэгний дотор хангаж 9 дүгээр сарын нэгний дотор хадлангийн төлөвлөгөөг 123,6 хувиар биелүүлж 5563 тонн өвс хураан авна.

6. Энэ онд саалийн бүх үнээ, нэмэхгунж, хонь ямаа, охин шидлэмг 1, 2 ээлжийн дулаан хашаатай болгож, шинээр бодын хашаа 12, тугалын цүнз 15, бөгийн хашаа 50, хурга нийгмийн цүнз 24-ийг барина.

7. Уурхайн худаг 3-ыг гаргаж, 2 худагт засвар хийнэ.

ХОЁР. Газар тариалангийн талаар

1. 1961 онд үр тариа, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал тариалах төлөвлөгөөг 104,5 га-г 550 га болгож тариална. Үр тариага бүрээс 9 ц. хүнсний ногоо төмс 10 т. байцаа 25 т. сонгино 0,8 т. манжин 20 т. эрдэнэ шим 160 т-ыг хураан авна.

ГУРАВ. Улсын бэлтгэл, үйлдвэр, худалдааны талаар

1. Сумын хэмжээгээр улсад тушаах малыг 5 хоногт багтааж төлөвлөгөөг хугацаанд нь 100,1 хувиар биелүүлнэ.

2. Төрөл бүрийн ноосыг тус тусын хугацаанд нь төлөвлөгөө ёсоор бэлтгэж ерөнхий дүнгээр нь ноос бэлтгэх улсын төлөвлөгөөг 10 дугаар сарын 1-ний дотор 102 хувиар биелүүлнэ.

3. Нэгдэл, мал бүхий иргэдээс улсад

тушаах сүүг 100 хувь, цөцгийн тос үйлдвэрлэх төлөвлөгөөг 10 дугаар сарын 1-ний дотор 103 хувиар биелүүлж 5340 л. сүү хэмнэж, бэлтгэх бүх тосгоо 1-рт үйлдвэрлэнэ. 1 кг тосонд зарцуулах сүүг 300 г-аар хэмнэнэ.

4. Түүхий эд, ангийн үс, хөлдүүгийн зүйлийн 1 дүгээр улирлын төлөвлөгөөг төрөл бүр дээр нь 100-150 хувиар биелүүлж чанарыг сайжруулах, бараа татаал ба бордуулах төлөвлөгөөг 101-103 хувиар биелүүлнэ.

ДӨРӨВ. Соёл ахуйн хангамжийн талаар

1. 1960-61 оны хичээлийн жилд сумын бага сургуулийн 4 дүгээр ангиас 21 хүүхдийг төгсгөж 1961-62 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид 20 хүүхдийг шинээр элсүүлж бүгд 71 хүүхэдтэйгээр хичээллэнэ.

Сургуулийн бэлтгэл засварыг 8 дугаар сарын 1-ний дотор багш ажилчдын хүчээр хийж дуусгана.

2. Сургуулийн хашааг цэцэрлэгжүүлж 50-аас доошгүй мод тарина.

3. Сумын улаан буланд сайн дурын уран сайханчид 30 хүнтэйгээр тогтмол ажиллаж, бригадад 10-15 хүний бүрэлдхүүнтэйгээр уран сайхны хэсгийг байгуулна.

4. Кино гараат ба үзүүлэх хүн, орлогын төлөвлөгөөний 70 хувийг 7 дугаар сарын 1-ний наана хангаж жилийн төлөвлөгөөг хугацааны нь өмнө 150-аас доошгүй хувиар биелүүлнэ.

5. Хүн эмнэлгийн урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг 105 хувиар, амбулаторийн үзлэгийн төлөвлөгөөг 110 хувиар, ор хоног ашиглах төлөвлөгөөг 102 хувиар биелүүлж төрөх тасгийг шинээр байгуулж ажиллуулна.

6. Сум-нэгдлийн төвд орон сууц, хөдөө аж ахуйн машины гараац, биеийн тамирын талбай, хүүхдийн цэцэрлэгийг барьж ашигдалтад оруулах ба хуучин барилгуудыг засварлана. Хонины Жаргалантын бригадын төвийг тохижуулна.

7. 60 км газраас телефон харилцааны шугам татаж ашигдалтад оруулах, сумын төвд телефон кумдатор тавьж албан газруудын хооронд ажиллуулах ба Ар урт, Марц, Хамар худагт утсан харилцаа тавина.

8. 1961 онд нэгдэлдээ 175000 хөдөлмөр өдөр бүтээж, 1445936 төгрөгийн орлого оруулж, орлогын 70 хувийг гишүүдийн хөдөлмөр-өдрийн хөлсөнд олгож 1 хөдөлмөр өдөрт 6 төгрөг өгнө.

Улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1961 оны төлөвлөгөөг амжилттай биелүүлэх тэмцэлд дээрх авсан үүргээ нэр төртэй биелүүлж чадна гэдгээ илэрхийлнэ.

Сум нэгдлийн хөдөлмөрчдийг

Сум-нэгдлийн дарга	ЧОЙНДОН
Намын үүрийн дарга	ЧИМИД
Эвлэлийн үүрийн дарга	ЦЭРЭНДОРЖ
ҮЭ-ийн хорооны дарга	ЦЭРЭН

Эрдэнэсантын сум-нэгдлийн дарга Ишжамц манай сурвалжлагчид ярьсан нь

Манай сум-нэгдлийн хан МАХН-ын 14 дүгээр их хурал, ардын хувьсгалын 40 жилийн ойг угтаж, 1961 оны улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөг зорилтыг биелүүлэхийн тулд тодорхой үүрэг авч ажилласан юм.

Тус сум энэ оны улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөг зорилтыг хэрхэн биелүүлэх тухай хөдөлмөрчдийн гэгээрлийн хурлаар хөдөлүүлж тэдний санал зөвлөгөөнийг авч социалист уралдааныг ажлын салбар бүрт өрнүүлж биелэлтийг үе үе дүнгээ, ажлын явцад гарсан төргүүний туршлагаудыг нийтэд

дэлгэрүүлэх, ажилд бүтээл гаргаж уралдаанд түрүүлэгчдийг урамшуулах ажил зохиож ирлээ.

Энэ нь хүмүүсийн хөдөлмөрийн идэвх санаачлагыг өрнүүлж төлөвлөгөөг ажлыг биелүүлэхэд асар их түлхэц болов.

Энэ жил манай сум-нэгдэл, аймгаас заасан хугацаанд бодын хялгас, хөөвөр бэлтгэх төлөвлөгөөг 101,8-117 хувь, ямааны ноолуурыг 101 хувь, тэмээний ноосыг 76 хувь, уртын ноосыг 75 хувь, мал бэлтгэлийг 100,2 хувиар биелүүлээд байна.

Хөдлүү түүхий эд, арс шир, ангийн үс, бэлтгэх 25

нэр төрлийн зүйлийн төлөвлөгөөг 6,2-75,8 хувиар давуулан биелүүлж анхны 5 сард 45000 хөдөлмөр-өдөр бүтээж 496000 төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөгөө 90 хувиар биелүүлэнэ.

Нэгдлийн хэмжээгээр бригадын хөдөлмөр зохион байгуулалтыг хийж төлөрүүлсэн нь гишүүдийн хөдөлмөрийг нэгтгэж, хамтарч ажиллаж сурч соёлжиход тус дөхөм үзүүлж байна.

Манай сум-нэгдэлд ямаа бүрээс 310-410 г. ноолуур ашигласан хоничин Дамцэрэн, Дамдамба, Чимэцэрэн, үхэр бүрээс 600-700 г. хөөвөр авсан саалийн Минжмаа, үхэрчин Бандь, төлөө 100-110 хувиар бойжуулсан хоньчин Содномдорж Сономжид, Балдандорж, Дамбасүрэн нарын төргүүний ажиллагаатай олон сайчуу-

дыг нэрлэж болно.

Малын их эмчийн салбар урьдчилан сэргийлэх тарилгын төлөвлөгөөг 100-245 хувь, МААМ станц хаврын тариалалтыг 126 хувь, пар хагалаалтыг 100,2 хувь, сүү тосны завод сүү авч, тос боловсруулах төлөвлөгөөг 23,7-29,6 хувь тус тус биелүүлнэ. Манай сум-нэгдэлд СХТ бригад 1, сэхэстний социалист нөхөрлөл 1, сурагчдын соёлч нөхөрлөл 1 байгуулагдаж тодорхой үүрэг аваад ажиллаж байна.

Төрчлөн аалбан газрууд өөрийгөө сурталчлах булантай болсон нь үр дүнгээ өгч байна.

Нэгдлийн бригад бүр ухуулах байртай болохын

хамт 10-20 хүнтэй сайн дурын уран сайханчдын зөвлөлт болж гэр бүлийн ба төрөл садангийн концерт тоглож төлөвлөгөөг ажлын ач холбогдлыг хөдөлмөрчдийн дотор сурталчилж байна.

Манай сум-нэгдлийн хамт олны эрчимтэй хөдөлмөрийн үр дүнд аймгийн графикт заасан 44 төрлийн зүйлээс 31-ийг биелүүлж 25 төрлийн туршлагаас 19 туршлагыг сум-нэгдлийн ажилд нэвтэрүүлж байна.

Одоо бид мал өсөлтийн 3 удаагийн судалгаанаас үзэхэд манай сумын мал уралдаанд авсан үүргийн хэмжээнд хүртэл өсөх боломжтой байна гэж ярилаа.

Хөдөө аж ахуйн нэгдлийн хөдөлмөрийн хөлсний асуудалд

ОРОС ХЭЛНИЙ БАГИШ НАРЫН СЕМИНАР

Ардын хувийн аж ахуйтныг хамтын аж ахуйд оршуулсан нэгтгэж дууссанаар манай хөдөө аж ахуйд социалист үйлдвэрлэлийн харьцаа ялж хөдөө аж ахуйд социалист эмч гол суурь эзлэх болжээ.

Хөдөө аж ахуйн социалист үйлдвэрүүд ялангуяа ХАА нэгдлийг аж ахуй, зохион байгуулалтын хувьд бэхжүүлж ашиг орлогыг дээшлүүлэх, нэгдлийн гишүүдийн байнга өсөж байгаа соёл ахуйн хэрэгцээг хангаж тэдний аж амьдралыг сайжруулах талаар нам засгаас ихээхэн арга хэмжээнүүдийг авсны ачаар сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйн нэгдлүүд томорч хүчин чадал нь өсөж үйлдвэрлэлийн нь хүрээ өргөжиж, хөдөлмөр зохион байгуулалт нь сайжирч, нэгдлийн гишүүд нийгмийнхөө үйлдвэрлэлд оролцох идэвх сонирхол нь сайжирч нэгдлийн ашиг орлого нь нэмэгдлээ.

Төв аймгийн хөдөө аж ахуйн нэгдлүүд 1960 онд 3373600 хөдөлмөр - өдөр бүтээж нийгмийн үйлдвэрлэлд 22,4 мянган гишүүд оролцсоны гадна 25 сая гаруй төгрөгийн орлоготой ажиллажээ.

1950 онд тус аймгийн ХАА нэгдлийн 50 гаруй хувь нь 500 хүртэл мянган төгрөгийн орлоготой ажиллаж байсан бол 1960 онд нийт нэгдлийн 90 хувь нь 1-2,5 сая ба түүнээс дээш төгрөгийн орлоготой ажиллажээ.

1960 онд аймгийн дундажаар 1 хөдөлмөр-өдөрт олгосон мөнгөний хэмжээ нь (мөнгөнд шилжүүлснээр) 1958 оныхоос 2,5 дахин өсөж хөдөлмөрийн чадвартай 1 гишүүний бүтээсэн хөдөлмөр-өдрийн хэмжээ 16,2 хувиар нэмэгдсэн байна.

Баянзүрх сумын Сүхбаатарын зам нэгдэл 2538 мянган төгрөг, Эрдэнэ сумын Монгол-Унгарын найрамдал нэгдэл 1600 мянган төгрөг, Баянцогт сумын Монгол-Хятадын найрамдал нэгдэл 2100 мянган төгрөгийн орлоготой ажиллаж дээрх нэгдлүүд нь хөдөлмөр-өдөрт 7-9 төгрөгийн мөнгө ба бие үйлдэхүүн хувиарлажээ.

Дээрх ололтууд бол хамтын том аж ахуйн давуу талтай батлах баталгаа нь мөн.

Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны 6 дугаар бүгд хурал ХАА нэгдлийн хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулж мал аж ахуйн үйлдвэрлэлийг орон нутгийн байгаль эдийн засгийн тодорхой нөхцөлд зохицуулан мал аж ахуйг төрөлжүүлэх ажлыг хийх ба нэгдлийн гишүүдийн хөдөлмөрийн хөлсийг мөнгөөр төлөх системд шилжин орох туршлагыг боловцоотой нэгдлүүд хийхийг зөвшөөрсөн билээ.

Бүгд хурлын энэ заалт бол хориолоогч олон материалыг сонирхлыг дээшлүүлж нийгмийн үйлдвэр-

лэлд хөдөлмөрийн бүтээмжийг эрс нэмэгдүүлж чадах орчин цагийн амни чухал асуудал мөн.

ХАА нэгдлийн нийгмийн үйлдвэрлэлд хөдөлмөрийн бүтээмж доод хэмжээнд байгаагийн уршгаар нэгдлийн гишүүдэд нийгмийн аж ахуйгаас орох орлого хомс байгаа одоо үед нэгдлийн гишүүдийн хувийн материалыг сонирхлыг дээшлүүлэх нь эдийн засгийн чухал ач холбогдолтой юм.

Материаллаг сонирхол, хөдөлмөрийн хөлс хоёр нь хоорондоо нягт холбоотой нэг нь нөгөөгүйгээр байж болохгүй зүйл юм.

Хөдөө аж ахуйн нэгдэлд материалыг сонирхлыг нээгдүүлэхдээ нийгмийн ба гишүүдийн хувийн сонирхол хоёрыг заавал хослон хэрэглэнэ.

Нэгдлийн гишүүдийн хувийн сонирхлыг нийгмийн аж ахуйн сонирхолтой хослож байгаа явдлыг зөвхөн гишүүдийн амни хувийн сонирхлын үүднээс үзэх явдал дутагдалтай бөгөөд гишүүдийн хувийн сонирхол дээшилснээр нэгдлийн нийгмийн үйлдвэрлэлд хамтын хөдөлмөрийн бүтээмж дээшлэж нийгмийн аж ахуйн ашиг орлого элбэгжиж гишүүдийн аж амьдрал нь сайжирч тэдний соёл ахуйн хэрэгцээг хангах эх сурвалж бүрдэнэ.

Нэгдлийн гишүүдийн хамтын хөдөлмөр бол хөдөө аж ахуйн нэгдлийн амьдралын үндэс мөн.

МАХН-ын Төв Хорооны 6 дугаар бүгд хурлын заалтыг биелүүлэхээр хөдөө аж ахуйн нэгдлийн хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрийн нормчлол, хөлс төлөлийн одоогийн байдалд судалгаа шинжилгээ хийж цаашид сайжруулах асуудал боловсруулах тухай МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл тогтоол гаргасан юм.

Энэ асуудлыг эрхэлсэн улсын төв комисс, аймгийн комиссууд байгуулагдаж ажиллаа орлоо.

Улсын хэмжээгээр бүх аймагт ХАА нэгдлийн хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрийн нормчлол хөлсний асуудалд судалгаа хийж байна.

Хөдөө аж ахуйн нэгдлүүдэд хөдөлмөрийн хөлсийг олгож байгаа одоогийн гол хэлбэр бол хөдөлмөр өдрөөр тооцож хөлсийг бие үйлдэхүүн, мөнгөөр олгож байна.

Нэгдлийн гишүүдийн хөдөлмөрийн хөлсийг мөнгөөр олгох шинэ хэлбэр тэргүүний зарим нэгдлүүдэд нэвтрч байна.

Хамтралын гишүүдийн хөдөлмөрийн хөлсийг мөнгөөр төлөх системд Зөвлөлт Холбоот Улс шилжиж ороод тэр нь сайн үр дүн өгч байгаа сайхан туршлага байна.

Нэгдлийн гишүүдийн хийсэн хөдөлмөр, хөдөлмөрийн хөлсийг хөдөлмөр - өдрөөр

үнэлдэг заримыг өөрчлөж мөнгөөр үнэлж нийгмийн аж ахуйн орлогыг мөнгөөр хувиарлах шинэ хэлбэрийг хэрэглэх нь наг үсэ олсон асуудал болжээ.

Хөлсний мөнгөн системд шилжиж байгаа явдал бол зөвхөн хөдөлмөрийн үнэлэлт нэгдлийн орлогыг хувиарлаж байгаа зарчмыг мөнгөөр сольж байгаа энгийн солилцоо биш улс төр, эдийн засгийн том арга хэмжээ мөн бөгөөд үүнтэй уялдуулж хөдөлмөрийн нормчлол, ажлын зэрэг тарифын сүлжлийг тогтоох, хөдөлмөр зарцуулалтын ба нягтлан бодох бүртгэл, тайлан, аж ахуйн дотоодын төлөвлөлт болон нэгдлийн гишүүдийн хөдөө аж ахуйн үйлдэхүүнээр яаж хангах нэгдлээс үйлдвэрлэл гаргаж байгаа үйлдэхүүнийг барлуулах зах зээлийн асуудал зэрэг эвдрэлтэй нарийн төлөгтэй асуудлуудыг хөндөж байгаа юм.

Мөнгөн хөлсөнд шилжиж байгаа явдал бол нэгдлийн гишүүдийн хөдөлмөрийн хөлсийг хөдөлмөр - өдрөөр үнэлж хөлсийг биет зүйл, мөнгөөр олгож байгаа одоогийн хэлбэрийг бодвол онцлогтой шинэ хэлбэр юм. Үүнд:

1. Хөдөлмөрийн мөнгөн хөлс нь баталгаат хөлс бөгөөд хөлсийн хэмжээг нэгдэл үйлдвэр-санхүүгийнхээ төлөвлөгөөндөө урьдаас төлөвлөн оруулдаг болох учир хөлсийн фонд маань биет ба мөнгөн орлогын үйлдвэрлэл байх чанараа алдаж хөлсөнд олгохоор урьдчилан төлөвлөж тогтоосон үйлдвэрийн зардалын хэсэг болж хувирах юм.

Гишүүдийн хөдөлмөрийн хөлсөнд олгох мөнгө бол нэгдлийн өөрийн хөрөнгө болох улсын бэлтгэлд нийлүүлэх үйлдэхүүний урьдчилгаанд авсан мөнгө, тодчилгаанд гаргасан үйлдэхүүний үнэ ба бусад орлого зэрэг эргэлтийн хөрөнгөөр санхүүжилдэнэ.

Баталгаат хөлс нь их, бага байх хэмжээ нь нэгдлийн эдийн засгийн хүчин чадалаас шалтгаалах зүйл юм.

2. Нийгмийн аж ахуйн бүх салбарт гүйцэтгэж байгаа ажил бүрд нэгж үйлдэхүүнд олгох хөлс нь мөнгөөр тооцогдоно.

Ийм болохоор гишүүдтэй хийх хөдөлмөр, хөлсний тооцоог дан мөнгөөр хийнэ.

Нэгдэл нэгдлийн гишүүдийн хоорондох материалын харьцаа товар мөнгөний харьцаа болж хувирах.

Энэ үед ХАА нэгдлийн гишүүдэд үйлдэхүүнийг хөдөлмөр-өдөрт шууд хувиарладаг явдал арлиж нэгдлээс хатуу тогтоосон үнээр худалдах болно.

3. Хөдөлмөрийн мөнгөн хөлс нь сар дутам тогтмол хугацаанд урьдчилгааж жилдээ хийсэн ажлын хөлсний нь ихэнх хэсэг 78-80 хувийг олгож үлдэж байгаа хөлсийг жилийн эцэст тооцож гишүүдийн хүсэлтийг харгалзан үйлдэхүүнээр буюу мөнгөөр олгоно.

4. Хөлсний мөнгөн сестемд шилжих явдал үйлдвэрлэлийн зардал хөдөлмөрийн хөлсөнд тавих төгрөгийн хяналтыг сайжруулж нэгдлийн үйлдвэрлэлийн салбар бүхэнд аж ахуйн тооцоог нэвтрүүлэх явдлыг хөнгөвчлөнө.

5. Хөдөлмөр зарцуулалтыг гүйцэтгэсэн ажлын хэмжээг мөнгөөр тооцож бүртгэх, үйлдэхүүнийг хувиарладаг журмыг худалдаа журмаар сольж байгаа явдал нь тайлан тооцоог ихээр хөнгөвчлөж нэгж үйлдэхүүнийг үйлдвэрлэхэд зарцуулж байгаа хөдөлмөрийн үнэ зөвөөр тогтоож өгнө.

6. Хөдөлмөрийн мөнгөн хөлс нь нэгдлийн нийгмийн үйлдвэрлэлд хөдөлмөрийн үнэ зөв нормчлол, тарифын сүлжлийг тогтооход өндөр шаардлага тавьж аж ахуйн салбаруудад адил хэмжээний ажил хийж түүндээ адил хэмжээний хөлс олгож байх бололцоог олгоно.

7. Хөдөлмөрийн хөлсний шинэ системд шилжмэгц нийгмийн үйлдвэрлэлийг төлөвлөж байгаа одоогийн зарчим, журмыг дахин хянахаас гадна сар дутамд олгох урьдчилгаа нь сарын мөнгөн орлого зарлага, үйлдвэрлэл гаргах нийт ба товарын үйлдэхүүн, хөлсөнд олгох мөнгөний хэмжээ зэрэгт шууд түшиглэнэ.

Хөдөлмөрийн хөлсийг мөнгөн системд оруулж амьдралд хэрэглэхдээ дээрх онцлогуудыг тал бүрээс нь тооцож үзэх хэрэгтэй юм.

Хөлсний мөнгөн системд сум-нэгдэл бүхэн үй адил арга журмаар нэгэн зэрэг шилжиж орох буюу түүнийг хэрэглэхдээ шүүмжлэлгүйгээр бие биенээсээ хуулбарлан хэрэглэж болохгүй.

Мөнгөн сестемд шилжиж орохын тул маш их бэлтгэл хэрэгтэй.

Юуны урьд хөдөлмөрийн нормчлол гишүүдийн хариуцаж байгаа малын хэмжээ зэргийг дахин хянаж үзэх ба хөдөө аж ахуйн бүх төрлийн ажил тарифийн сүлжлийн хөлсний үнэлгээ тогтоож, хөдөлмөрийн хөлсийг сар дутам олгож байх мөнгөний фонд, түүний эх булгийг урьдаас тогтооно олох хэрэгтэй юм.

(Үргэлжлэл нь дараагийн дугаарт)

Аюулгүйн зөвлөлд

НЬО-НОРК, 7 дугаар сарын 1. (МОНЦАМЭ). НЬО-ын Аюулгүйн Зөвлөлийн даргаас Аюулгүйн Зөвлөлийн гишүүдэд хандаж Иракийн талаар Кувейтын мэдүүлсэн гомдлыг аяч хэлэлцэхээр өнөө орой хуралдаан хийхийг санал болгов.

МОСКВА, 6 дугаар сарын 30. (МОНЦАМЭ). Социалист орнуудын дээд сургуулиудын орос хэлний багш нарын 4 дэх улаагийн тогтмол семинар Москвагийн их сургууль дээр 1 сар үргэлжилж өнөөдөр ахлаа дууслаа.

Семинарт Унгар, БНАГУ, БНАВУ, БНАХУ, БНПАУ, БНМАУ зэрэг орны төлөөлөгчид ороцож орос хэл заах, туршлага солилцох, ярианы хэл сайжруулах далаага хийлээ. Зөвлөлийн хэл бичгийн нэрт эрдэмтэн академич В. Виноградов, профессор В. Беляев, Н. Жинки, З. Цветкова зэрэг хүмүүс лекц уншсан байна.

Кувейтын байдал

ЛОНДОН, 7 дугаар сарын 1. (МОНЦАМЭ). Английн батлан хамгаалах яамнаас мэдээлснийг үзвэл, өнөөдөр английн «Булверк» хэмээх нисэх онгоц тээгч хөлөг онгоцор тэнгисийн явган цэргийн ангидыг Кувейтэд буулгажээ.

Тус хөлөг онгоц 600 цэрэг суулгаж 6 дугаар сарын 29-нд Карачийн усан буудлаас гарсан аж.

Кувейтэд командосын дайрагч отрядууд, тэнгисийн явган цэргүүд морин цэргийн эскадронос гадна «Центурион» гэдэг 14 тавк авчсан тухай английн цэргийн яамны төлөөлөгч мэдэгдлээ.

«Хантер» гэдэг тийрэлтэт 12 нисэх онгоц Кувейтын нисэх онгоцны буудалд бас очжээ.

ПАРИС, 7 дугаар сарын 1. (МОНЦАМЭ). Иракийн ерөнхий сайд Касем сар-гүүдлээ Кувейтын нутагт нэвтрэн орох тушаал өгөв гэж Кувейтын радио өнөөдөр мэдэгдсэнийг Франс Пресс агентлагийн сурвалжлагч Кувейтээс уламжлав.

Кувейтын захиргагч Англи, Саудын Арав улсуудад хандаж тусламж эрсэн тухай уг радиогоор бас мэдэгджээ.

ПАРИС, 7 дугаар сарын 1. (МОНЦАМЭ). Франс Пресс агентлагийн сурвалжлагч Багдадаас уламжлалыг үзвэл, өнөөдөр Иракийн засгийн газар Ирак-Кувейтын хил дээр Иракийн цэрэг бөөгнөрч байгаа тухай мэдээг албан ёсоор илгээв.

Иракийн засгийн газрын энэхүү илгээлтийг Багдадын радиогоор нэвтрүүлжээ.

Английн цэрэг Кувейтэд очсон ньдлын талаар өнөөдөр Багдадын радио эрс эсэргүүцэл тавив.

Багдадын радио энэ ажиллагааг «Зүй зохист огтний-цэхгүй хэрэг» гэж нэрлээд үүнийг бүх харуулагч Кувейтын Эмир хүлээх болно гэж заажээ.

Хариуцагдай эрхлэгчийг М. БАЯНХҮҮ